

**Mongolian language for foreigners – Week 13**  
**Lecture №13**

**Сэдэв: Монголчуудын үндэсний баяр- Цагаан сар**  
**Topic: Mongolian National Festival-Lunar New Year**

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**  
**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts And Culture**  
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын үндэсний баяр– Mongolian National Festival- Lunar New Year
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework



Цагаан сар [Photograph]. (2013, January 13). mn.wikipedia.org.  
[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD\\_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan\\_sar\\_5.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan_sar_5.jpg)

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест

1. Монголчуудын уламжлалт аж ахуй нь .....мал аж ахуй юм.

А. Нүүдлийн      Б. Суурин      В. Хашааны      Г. Уулын

2.....үхэр, хонь, ямааны хөөрүүлсэн сүүгээр бүрдэг бөгөөд зун цагт ихэвчлэн оройн хоолонд хэрэглэдэг.

А. Таргийг      Б. Хоормогийг      В. Эззгийг      Г. Айргийг

3. Шар тос нь .....ихтэй учраас эрүүл мэндэд маш тустай.

А. Илчлэг      Б. Нүүрс ус      В. Уураг      Г. Эрдэс

4. Буцалгасан айргаа хөргөж, тааран уутанд хийж шүүгээд .....гаргаж авна.

А. Ааруул      Б. Эззгий       В. Аарц      Г. Ээдэм

5. Гүүний сүүг исгэн .....гаргаж авдаг.

А. Архи      Б. Хоормог      В. Тараг       Г. Айраг



*Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.*

1. Монголчуудын уламжлалт ямар ямар баяр байдаг вэ?
2. Цагаан сар хэзээ болдог вэ?
3. Монголчууд цагаан сарыг яаж тэмдэглэдэг вэ?
4. Цагаан сар яагаад чухал баяр вэ?

# Монголчуудын үндэсний баяр Mongolian National Festival-Lunar New Year

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. *Айл хотол – neighbours*
2. *Албан ёсоор – officially*
3. *Амар мэндийг нь мэдэх – to greet respectfully*
4. *Ардын ёс заншил – traditional custom*
5. *Бэлгэтэй сайхан үг – good words custom*
6. *Зарлиг гаргах – to issue a decree*
7. *Золгох – to greet and kiss each other*
8. *Идээ – food set for guests*
9. *Мөрөө гаргах – to make a first step of the new year*
10. *Өвлийг давах – to survive winter*
11. *Өндөр настай хүмүүс – senior citizens*

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

12. Төрөл садан – *relstives*
13. Тэмдэглэх – *to record*
14. Уул, овоондоо мөргөх – *to pray mountans and Ovoos*
15. Үе – *layer*
16. Хаан ширээнд суух ёслол – *the Coronation Ceremony*
17. Хавартай золгох – *to see spring*
18. Хүндэтгэлтэй – *respectful*
19. Цагаан идээ – *dairy products*
20. Цагаалга – *special food made of mairy products for Tsagaan Sar ceremony*
21. Шүүс зоог – *feast*
22. Элбэг хоол унд – *plenty of meal*

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг**


Цагаан сар бол Монгол үндэстний хамгийн 1) \_\_\_\_\_ том баяр юм. Цагаан сарыг анх намар тэмдэглэдэг байжээ. Намар сүү, цагаан идээ, хоол хүнсээр элбэг байдаг болохоор байгаль дэлхийдээ талархаж, 2) \_\_\_\_\_ баяр хийдэг байжээ. XIII зууны эхээр Чингис хаан олон аймгуудыг нэгтгэн, Их монгол улсыг байгуулаад гуравдугаар жарны хөхөгчин үхэр жилийн өвлийн сүүл сарын эцсээр хаан ширээнд суух 3) \_\_\_\_\_ хийжээ.

# Монголчуудын үндэсний баяр Mongolian National Festival-Lunar New Year

## ЦАГААН САР



Архивын ерөнхий газар. (2019, February 5).  
Цагаан сар [Photograph]. news.mn.  
<https://news.mn/r/2085842/>



Арьяасүрэн, Ч. (2013, February 11). Цагаан сарын түүх,  
соёл [Photograph]. news.mn.  
<https://news.mn/r/621734/>



Цэрэнсодном, Д. (2009, February 24). Цагаан сар  
[Photograph]. gogo.mn.  
<https://gogo.mn/r/50234>

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг**

Энэ ёслолыг хийхдээ намар тэмдэглэдэг байсан цагаан сарыг хаврын сард албан ёсоор шилжүүлж хамт тэмдэглэжээ. Ийнхүү 1206 оноос эхлэн цагаан сарыг хавар тэмдэглэдэг болов. Цагаан сар нь хүйтэн өвлийг давж, урин дулаан хавартай золгосны баяр, мөн шинэ он гарч, нэг 4)\_\_\_\_\_ баяр юм. Монголчууд өмнө нь төрсөн өдрийн баяр гэж тусгай баяр хийдэггүй байлаа. Цагаан сараар нас нэмсний баяраа хамт тэмдэглэдэг байв.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг**

Цагаан сарын баярт зориулан, элбэг хоол унд, цагаан идээ бэлддэг. Баяраар хүмүүс шинэ, сайхан хувцсаа өмсч, бэлгэтэй сайхан зүйлсийн талаар ярилцдаг. Учир нь энэ өдөр идээ ундаа элбэг, хүмүүс баяр баясгалантай байвал ирж байгаа 5) \_\_\_\_\_ тийм байна гэж үздэг. Бэлддэг гол хоол хүнс нь тавгийн боов, бууз, мах, цагаан идээ юм.

# Монголчуудын үндэсний баяр Mongolian National Festival-Lunar New Year

## Цагаан сарын идээ, шүүс



Цагаан сарын тавгийн идээ [Photograph]. (2013, January 13). mn.wikipedia.org. [https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD\\_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan\\_sar\\_4.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan_sar_4.jpg)



Эрдэнэбат, Г. (2020, March 5). Цагаан сарын идээ, шүүс [Photograph]. montsame.mn. <https://montsame.mn/mn/read/217834>

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг*

Монголчууд цагаан өнгийг сайн сайхны бэлгэ тэмдэг гэж үздэг учраас ажил, амьдрал, бүх юмаа цагаан өнгө шиг ариун байгаасай гэж хвсч, шинэ оны 6) \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ “Цагаан сар” гэж нэрлэжээ.

Чингис хаан 1216 оноос эхлэн, цагаан сараар өндөр настай хүмүүст хишиг хүртээж байх зарлиг гаргаснаас хойш одоо хүртэл энэ зарлиг хадгалагдсаар байна. Төр засаг, байгууллагууд ахмад настнуудаа урьж, бэлэг өгдөг.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах,  
нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг*

Цагаан сарын баяр нь 7) \_\_\_\_\_, \_\_\_\_\_ гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ.

**Битүүлэх:** Өвлийн адаг сарын 30-ны өдрийг битүүн гэдэг. Учир нь сар бүрийн 30-нд сар гардаггүй. Энэ өдөр Монгол хүмүүс гэр орон, малын хашаа хороогоо цэвэрлэж, шинэ дээл хувцасаа бэлдэж тавина. Цагаан сарын тавгийн идээг өрж, шүүс зоогоо чанаж бэлэн болгоно.

# Монголчуудын үндэсний баяр Mongolian National Festival-Lunar New Year

## БИТҮҮЛЭХ ЁС



Битүүн [Photograph]. (2018, February 6).  
[www.ugluu.mn](http://www.ugluu.mn). <https://www.ugluu.mn/327917.html>



Өлзийсайхан, Д. (2020, February 23). Цагаан сар [Photograph]. [montsame.mn](http://montsame.mn).  
<https://montsame.mn/mn/read/216911>

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг**

Таваг засахдаа залуучууд гурван үе, дунд, ахмад настнууд таван үе, өндөр настнууд долоон үе боов өрж 8)\_\_\_\_\_ . Орой айл бүр гэр гэртээ мах чанаж, бууз жигнэн, сүү, аарц, ундаагаар цагаалга бэлдэж, ам бүл, айл хотлоороо хамт оны сүүлчийн зоог барьдаг. Үүнийг битүүлэг гэнэ. Энэ нь өнгөрөн одож буй оноо битүүлэн үдэх ёс юм. Битүүний орой хүн бүр сайн хоол идээг цадтал ууж, идэх ёстой.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах,  
нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг*

**Золгох:** Шинийн нэгний өглөө хүн бүр үүр цайхаас өмнө эртлэн босч, хамгийн сайхан дээл, хувцасаа өмсөнө. Гэрийн томчууд мөрөө гаргаж, эрчүүд уул, овоондоо мөргөнө. Дараа нь нар гарахад 9)\_\_\_\_\_ эхэлнэ. Эхлээд гэр бүл дотроо золгоно.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах, нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг*

Золгохдоо дээл хувцасныхаа товчийг бүрэн товчилж, малгай өмсөн, ханцуй нударга буулган золгоно. Ахмад настай, хүндтэй хүмүүстэй 10)\_\_\_\_\_ барин золгодог. Золгохдоо насаар дүү хүн ахмад хүнийг хүндэтгэн гараа ахмад хүний гар доогуур зөрүүлж, ахмад хүний тохойг өргөн золгоно. Үеийн хүн бол нэг гараа дээгүүр, нөгөө гараа доогуур зөрүүлж золгоно.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаан идээний, цагаалга, битүүлэх/цагаалах,  
нас нэмсний, ёс заншил, хүндэтгэлтэй, таваг засна, шинэ онд, хадаг, ёслол, эхний сарыг*

**Зочдыг дайлах ёс:** Ирсэн зочинд ажил үйлс нь ариун цагаан байхыг бэлгэдэн гэрийн эзэгтэй хамгийн түрүүнд цагаан идээгээр хийсэн 11)\_\_\_\_\_ амсуулж дараа нь цай аягалж өгнө. Зочид цай уусны дараа тавагтай идээнээс амсч, бууз хоолноос иддэг. Настай хүмүүс хүүхэд, залуучуудад бэлэг өгдөг. Энэ баяраар хүмүүс гэр бүл, үр хүүхдээ дагуулан ахмад настай төрөл садангууддаа очиж золгон, амар мэндийг нь мэдэж, хүүхдүүдээ ах дүү, төрөл садан, ардын 12)\_\_\_\_\_ танилцуулдаг.

# Монголчуудын үндэсний баяр Mongolian National Festival-Lunar New Year

## Цагаан сарын шинийн нэгэн



Гантуяа, Н. (2018, February 16). Монгол түмний уламжлалт цагаан сар [Photograph]. montsame.mn. <https://montsame.mn/ru/read/81216>



Арьяасүрэн, Ч. (2019, February 4). Монгол уламжлалт ёс [Photograph]. www.inews.mn. <https://www.inews.mn/a/5640>

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 3. Өгүүлбэрийг үгүйсгэх утгатай болгоно уу.**  
**Exercise 3.**

1. Цагаан сарыг өвлийн улиралд тэмдэглэдэг.

Цагаан сарыг өвлийн улиралд тэмдэглэдэггүй.

2. Цагаан сар 5-р сард болдог.

.....

3. Цагаан сарын эхний өдрийг битүүлэх гэж нэрлэдэг.

.....

4. Цагаан сар бол Чингис хааны төрсөн өдөр юм.

.....

5. Залуу хүмүүстэй хадаг барьж золгох хэрэгтэй.

.....

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 3. Өгүүлбэрийг үгүйсгэх утгатай болгоно уу.**  
**Exercise 3. Make the sentences negative.**

6. Цагаан сарыг өвөл тэмдэглэдэг байсан.

.....

7. Цагаан сараар хуучин, хиртэй хувцас өмсөж болно.

.....

8. Цагаан сарын тавгийн идээг 4,6,8 үеэр өрдөг.

.....

9. Цагаан сараар ахмад хүнтэй хамгийн сүүлд золгодог.

.....

10. Америкчууд цагаан сар тэмдэглэдэг.

.....

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

*Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 4. Discuss about following questions and review your understanding*

1. Цагаан сарыг анх яагаад намар тэмдэглэдэг байсан бэ?
2. Цагаан сарыг яагаад хавар тэмдэглэдэг болсон бэ?
3. Цагаан сар ямар утгатай баяр вэ?
4. Цагаан сараар яагаад шинэ сайхан хувцас, элбэг дэлбэг идээ ундаа бэлддэг вэ?
5. Энэ баярыг яагаад “Цагаан сар” гэж нэрлэсэн бэ?

*Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 4. Discuss about following questions and review your understanding*

6. “Битүүн” гэж юу вэ? Яагаад битүүн гэж нэрлэсэн бэ?
7. Битүүний өдрийг хүмүүс яаж тэмдэглэдэг вэ?
8. Шинийн нэгний өглөө хүмүүс юу юу хийдэг вэ?
9. Цагаан сараар хүмүүс яаж золгодог вэ?
10. Цагаан сараар айлд ирсэн зочин идээ амсахдаа ямар ёсыг дагадаг вэ?

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

**Дасгал 5. Өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.**  
**Exercise 5. Complete the sentences.**

1. Битүүний өдөр .....-аа чанадаг.
2. Хамгийн том монгол .....9 метр өндөр, 6 метр урт.
3. Дээлийн.....-ийг нар зөв эргүүлэн бүсэлдэг.
4. Баяр наадмаар.....-ыг гурав, тав, долоо, ес давхарладаг.
5. Золгохдоо .....-гаа заавал өмсөх ёстой.
6. Монголчууд цагаан, шар, цэнхэр, улаан, ногоон өнгийн  
.....хэрэглэдэг.
7. ....бол монголын үндэсний хувцас юм.
8. ....-ийг хамгийн сайн чанарын чулуугаар хийдэг.
9. Цагаан сараар айл болгон.....хийдэг.

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

Гэрийн даалгавар 1  
Homework 1

Мэдлэг шалгах тест

1. Хаврын эхэн сард болдог \_\_\_\_\_ бол Монгол үндэсний хамгийн том баярын нэг.  
А. Монгол наадам      Б. Төлийн баяр      В. Цагаан сар      Г. Шинэ жил
2. Цагаан сарыг анх сүү, цагаан идээ, хоол хүнсээр элбэг байдаг \_\_\_\_\_ тэмдэглэдэг байжээ.  
А. Хавар      Б. Зун      В. Намар      Г. Өвөл
3. Цагаан сар нь хүйтэн өвлийг давж, урин дулаан хавартай золгосны баяр мөн шинэ он гарч, нэг \_\_\_\_\_ баяр юм.  
А. Жил өнгөрсний      Б. Нас нэмсний      В. Зочин ирсний      Г. Ажил дууссаны
4. Цагаан сарын баяраар хүмүүс шинэ, сайхан хувцсаа өмсөж \_\_\_\_\_ зүйлсийн талаар ярилцдаг.  
А. бэлгэтэй сайхан      Б. сонин хачин      В. инээдтэй хөгжилтэй      Г. өөрт тохиолдсон
5. Цагаан сараар бэлддэг гол хоол хүнс нь тавгийн боов, \_\_\_\_\_, мах, цагаан идээ юм.  
А. бууз      Б. гурилтай шөл      В. пицца      Г. шарсан тахиа

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

Гэрийн даалгавар 1  
Homework 1

6. Монголчууд \_\_\_\_\_ өнгийг сайн сайхны бэлгэ тэмдэг гэж үздэг учраас шинэ оны эхний сарыг Цагаан сар гэж нэрлэдэг.
- А. улаан                      Б. цэнхэр                      В. цагаан                      Г. ногоон
7. Цагаан сарын баяр нь \_\_\_\_\_, \_\_\_\_\_ гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ.
- А. битүүлэг, цагаалга      Б. дайлах, дайлуулах      В. угтах, үдэх              Г. цай, хоол
8. Өвлийн адаг сарын 30-ны өдрийг \_\_\_\_\_ гэдэг.
- А. сүүлчийн өдөр          Б. битүүний өдөр              В. шинэ жил                  Г. цагаан сар
9. Шинийн нэгний өглөө нар гарахад \_\_\_\_\_ эхэлнэ.
- А. айлчлал                      Б. золголт                      В. зоог                          Г. амралт
10. Ахмад настай, хүндтэй хүмүүстэй \_\_\_\_\_ барин золгодог.
- А. ном                              Б. мөнгө                          В. торго                          Г. хадаг

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

---

Гэрийн даалгавар 2  
Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.  
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны үндэсний баярын талаар бичээрэй.  
Write about the national festival in your country*

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Цагаан сар [Photograph]. (2013, January 13). mn.wikipedia.org.

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD\\_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0)

[%BB:Chagaan\\_sar\\_5.jpg](#)

Архивын ерөнхий газар. (2019, February 5). Цагаан сар [Photograph]. news.mn.

<https://news.mn/r/2085842/>

Арьяасүрэн, Ч. (2013, February 11). Цагаан сарын түүх, соёл [Photograph]. news.mn.

<https://news.mn/r/621734/>

Цэрэнсодном, Д. (2009, February 24). Цагаан сар [Photograph]. gogo.mn.

<https://gogo.mn/r/50234>

Цагаан сарын тавгийн идээ [Photograph]. (2013, January 13). mn.wikipedia.org.

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD\\_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0)

[%BB:Chagaan\\_sar\\_4.jpg](#)

Эрдэнэбат, Г. (2020, March 5). Цагаан сарын идээ, шүүс [Photograph]. montsame.mn.

<https://montsame.mn/mn/read/217834>

Битүүн [Photograph]. (2018, February 6). [www.ugluu.mn](http://www.ugluu.mn).

<https://www.ugluu.mn/327917.html>

Өлзийсайхан, Д. (2020, February 23). Цагаан сар [Photograph]. montsame.mn.

<https://montsame.mn/mn/read/216911>

Гантуяа, Н. (2018, February 16). Монгол түмний уламжлалт цагаан сар [Photograph]. montsame.mn.

<https://montsame.mn/ru/read/81216>

Монголчуудын үндэсний баяр  
Mongolian National Festival-Lunar New Year

Дараагийн хичээл хүртэл  
баяртай!



Цагаан сараар хадагтай золгох [Photograph]. (2013, January 13).  
mn.wikipedia.org. [https://mn.wikipedia.org/wiki/  
%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD\\_%D1%81%D0%B0%D1%80#/media/  
%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan\\_sar\\_3.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D1%81%D0%B0%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chagaan_sar_3.jpg)